БАТЛАВ:
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.БӨӨРВАЯР

БАТЛАВ:
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

ХӨВСГӨЛ АЙМАГ, АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАРИГДАХ "НАЙРАМДАЛ-2 ОЛОН УЛСЫН ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН АМРАЛТ ХӨГЖЛИЙН ЦОГЦОЛБОР"- ЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны 5 дугаар сарын 21-ны өдөр Дугаар: 2021/28 Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	• Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжын жагсаалт, Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль • Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн Олон улсын хүүхдийн "Найрамдал-2" зуслан байгуулах тухай 205 дугаар тогтоол; • Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 32 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт; • Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаал.
2	Зорилго, ач холбогдол	Дотоод, гадаадын хүүхэд, өсвөр үе, залуучуудыг байгалийн сайханд амраах, Монгол өв соёлыг өвлүүлэх, сурталчлах үүгээр дамжуулан бие хүний хөгжил боловсрол, ёс зүй, ухамсарт эерэгээр нөлөөлж хариуцлагатай, хүнлэг иргэн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх олон улсын шаардлагад нийцсэн аялал жуулчлал, амралт хөгжлийн цогцолбор бий болно.
3	Байршил, газар олголтын тогтоол, захирамж	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалаар "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын Хайчийн ам нэртэй байршилд 60 га газар" олгогдсон.
4	Зориулалт хүчин чадал /Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлөөр/	1. Амралтын өвлийн байр болон Зуны хотхон нийлээд 1000 хүүхдийн хүчин чадалтай. ❖ А.Өвлийн амралтын байр – 528 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай байх; ❖ Б.Зуны амралтын хотхон – 480 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай байх; 2. Соёл урлагийн ордон- 700 хүний суудалтай; ❖ Их танхим 600 суудалтай; ❖ Бага танхим 100 суудалтай; 3. Сургалт, хөгжил бүтээлийн ордон- 528 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай /спорт заал, усан сантай/; 4. Захиргаа; 5. Эмнэлгийн байр; 6. А. Өвлийн хоолны газар - 1 ээлжиндээ 500 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай; Б.Зуны хоолны газар - 1 ээлжиндээ 500 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай;

		7. Гадаад, дотоодын зочид төлөөлөгчид байрлах зочид буудал – 40 ортой, 18 өрөө; 8. Гадна байгууламж, тохижилт; 9. Ажилчдын орон сууц – 72 айл /Хатгалд байж болох/; 10. Автограж –30 автомашины багтаамжтай /засвар, дархан, мужааны цехтэй/.
5.	Барилгажих талбай /Барилгын бүрхэцийн харьцаагаар/	Давхар талбайн харьцаа ДТХ-10; Барилгын бүрхцийн харьцааны 0.5 үзүүлэлтийг баримтлан эзэмшил газрын 50%-иас дээшгүй талбайд барилгажуулах. /судалгааны ажлын явцад холбогдох норм, дүрмийн дагуу дахин нарийвчлан тооцох/
6.	Барилгын давхрын тоо	1. Амралтын байр: - А. Өвлийн байр – 3 давхар /зоорийн давхартай/; - Б. Зуны байр – Хотхоны төлөвлөлтөөр барих /тухайн хотхоны онцлогоос шалтгаалж 1-2 давхараар төлөвлөх/. 2. Соёл урлагийн ордон – 2 давхар /зоорийн давхартай/; 3. Сургалт, хөгжил бүтээлийн ордон – 2 давхар /зоорийн давхартай/; 4. Захиргаа – 2 давхар /зоорийн давхартай/; 5. Эмнэлгийн байр - 1 давхар; 6. Хоолны газар: - А.Өвлийн хоолны газар 1 давхар /зоорийн давхартай/; - Б.Зуны хоолны газар 1 давхар. 7. Эцэг, эхчүүд болон зочид байрлах зочид буудал – 3 давхар /зоорийн давхартаа дулаан зогсоолтой/; 8. Ажилчдын орон сууц – 3 давхар /зоорийн давхартаа автомашины дулаан зогсоол, техникийн өрөөтэй/.
7.	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага	- Эдэлбэр газрын талбайг дотор нь хүүхдийн амралтын, спортын, үйлчилгээний, аж ахуйн, хог хаягдлын гэсэн 5 үндсэн бүсэд ангилан төлөвлөх; - Зуслангийн зориулалттай үндсэн барилгын гадна төрх загвар нь орчин үеийн хэв маяг бүхий тухайн газар нутаг, байгалийн тогтоцтойгоо хосолсон байх. /Архитекторийн өвөрмөц төрх загвартай байх/; - Амралтын бүсийг хүүхэд чөлөөт цагаа аюулгүй орчинд өнгөрөөх, тоглох үндэсний хэв загвартай тоглоомын талбай, инстоляци, спортын талбай, ногоон байгууламжтай байх ба аж ахуй, зочидын хэсгээс зайтай төлөвлөх; - Хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах /хүүхэд төөрөх, далайруу орох, ой модруу орох гэх мэт эрсдлийн судалгаа хийх, эрсдлээс хамгаалах арга хэмжээг зураг төсөлд заавал тусгах/; - Хог цуглуулах талбай руу орох орц бие даасан, хүрэх зам нь хатуу хучилттай, хог цуглуулах талбай нь хаалт бүхий тусгаарлагчтай байх. Хогийг ангилан хаях цэг төлөвлөх; - Эдэлбэр газрын талбайн 50%-иас багагүй талбай нь ногоон байгууламж байх ба онгон байгалийг хэвээр хадгалах/; - Эдэлбэр газрын талбайн гэрэлтүүлгийг холбогдох нормын дагуу төлөвлөх;

		- Авто зам тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарцыг холбогдох стандартын дагуу төлөвлөх; - Барилгын орчны байгууламж руу очих явган хүний зам хатуу хучилттай байхаар төлөвлөх. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлага:** - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоол төлөвлөх; -Явган хүний зам нь хатуу, нягт, халтирахаас сэргийлсэн гадаргуугаар хийгдсэн байх бөгөөд хөтөч хавтан төлөвлөх; - Налуу замыг стандартын дагуу 1:12, бариултай төлөвлөх; - Онцгой нөхцөлд ашиглах орц, гарц төлөвлөх.
8.	Архитектур төлөвлөлтийн шаардлага	**1. А. ӨВЛИЙН АМРАЛТЫН БАЙР** **Өвлийн ээлжинд 528 хүүхдийн хүчин чадалтай:** ❖ 11 бүлэгтэй байна; ❖ 1 бүлэгт 8 өрөө байна; ❖ 1 бүлгийн 8 өрөөний 1 өрөө нь тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулагдсан байна; ❖ 1 өрөө 6 хүүхэдтэй байна; ❖ Өрөө дотроо ариун цэврийн өрөө, шүршүүртэй байна; ❖ Хэрэглээний /цагаан хэрэглэл/ болон амрагчдын лифт тусдаа байна; ❖ Аваар ослын үед хүүхдүүд богино хугацаанд байрнаас гарах стандартад заасан тоогоор хаалга төлөвлөх; ❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангасан байх. **Зоорийн давхарт:** - Техник узелийн өрөө; - Угаалгын цех /хоногт 200 хос цагаан хэрэглэл угааж ариутгах хүчин чадалтай/; - Угаалга; - Ариутгал; - Хатаалт; - Зөөлөн эдлэлийн цэвэр бохирын агуулах; - Ажилчдын өрөө; - Хувцас солих өрөө; - Үйлчилгээний ажилчдын ажлын өрөө; - Агуулах; - Ариун цэврийн өрөө, шүршүүр; - Хэрэглээний лифт /цагаан хэрэглэл/; - Лифт; - Шатны хонгил; - Цагаан хэрэглэлийн бункер; - Хогийн бункер. **1-р давхарт:**
		- Бүртгэл мэдээллийн хэсэг; - Хүүхэд хүлээн авах хэсэг; - Үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах хэсэг; - Эмчийн өрөө;

		- Сэтгэл зүйчийн өрөө; - Эргэлт уулзалтын өрөө; - Нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Тусгай хэрэгцээт хүүхдийн ариун цэврийн өрөө; - Байрны зохион байгуулагчийн өрөө; - Хурлын өрөө-30 хүний суудалтай /багш нарын хэрэгцээнд/; - Багш нарын ажлын өрөө /том заалаар төлөвлөж/; - Агуулах; - Интернет танхим/50 хүний багтаамжтай/ шаардлагатай үед ашиглах, олон улсын статусын хүрээнд зайлшгүй байх; - Дэлгүүр /хүнс, бэлэг дурсгал/; - Аюулгүй ажиллагааны хяналтын өрөө; - Цагаан хэрэглэлийн бункер; - Шатны хонгил; - Лифт. **Бусад давхарт:** - Хүүхдийн амрах өрөө; - Бүлэг тус бүрд багш нарын өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Шүршүүр /эрэгтэй эмэгтэй/; - Бүлэг тус бүрд чөлөөт цагийн танхим; - Цагаан хэрэглэлийн бункер; - Хогийн бункер; - Нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй эмэгтэй/; - Шатны хонгил; - Лифт. **1.Б. ЗУНЫ АМРАЛТЫН ХОТХОН** ❖ *Хотхон тус бүр өөр өөрийн онцлог өвөрмөц шийдэл бүхий хэв загвартай байх.* - Хүчин чадал: 480 хүүхдийн хүчин чадалтай; - 1 хотхон 48 хүүхдийн хүчин чадалтай нийт 10 хотхон байх - Хотхон тус бүр 2 багшийн өрөөтэй; - Хотхон тус бүрт бүлгийн ажил зохион танхим байх /48 хүүхдийн хүчин чадалтай/; - Хотхон тус бүр эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө болон эрэгтэй, эмэгтэй дүштэй байх. **2. СОЁЛ УРЛАГИЙН ОРДОН** **Хүчин чадал:** Их танхим 600, бага танхим 100 хүүхдийн хүчин чадалтай. **Зоорийн давхарт:** - Хувцасны өлгүүр; - Нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Бага танхим.

		1-р давхарт: - Хувцасны өрөө /эрэгтэй/; - Хувцасны өрөө /эмэгтэй/; - Буфет; - Шатны хонгил; - Тайз /эргэдэг/; - Хөгжмийн яам /эвхэгддэг байх/; - Тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө; - Жижүүрийн өрөө; - Хувцасны өлгүүр; - Үзэсгэлэнгийн танхим /коридор хэсгийг ашиглаж төлөвлөх/; - Үзвэрийн танхим; - Дотоод хэрэгцээний ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Цахилгааны өрөө; - Үйлчилгээний ажилтны өрөө; - ИТА өрөө; - Оёдол, чимэглэл, жижиг хэрэгслийн өрөө; - Техникийн агуулах; - Хувцасны агуулах; - Бэлтгэлийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/. **2-р давхарт:** - Зочны өрөө. - Ариун цэврийн өрөөтэй; - Бель-этаж, партер, лоож; - Зохион байгуулагчын өрөө; - Гэрэлтүүлгийн лоож; - Пультны удирдлагын өрөө; - Техникийн өрөө; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/. ❖ *Гэрэл, техник, дуу авианы тоноглолыг олон улсын стандартын шаардлагад нийцсэн дэвшилтэт технологи ашигласан байх;* ❖ *Хүндэт зочдын тусгай суудал /тайзны эгц урдаас харсан партер эсвэл бель-этажд байршуулж болно/;* ❖ *Аваар ослын үед хүүхдүүд богино хугацаанд танхимаас гарах 4-өөс доошгүй хаалга төлөвлөх;* ❖ *Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан эгнээг төлөвлөх;* ❖ *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангасан байх;* ❖ *Акустикийг олон улсын стандартын дагуу шийдэх.* **3. СУРГАЛТ, ХӨГЖИЛ БҮТЭЭЛИЙН ОРДОНЫ БАРИЛГА** ❖ *Сургалт, хөгжил бүтээлийн ордоны барилга нь А болон Б хэсгүүдээс бүрдэнэ;* ❖ *528 хүүхдийн хүчин чадалтай;* ❖ *50 хүртэлх хүүхдийн багтаамжтай 16-аас доошгүй сургалтын танхимтай;*

		❖ *ОУ-ын стандарт шаардлагад нийцсэн спорт заалтай байх /500 хүүхдийн үзэгчийн суудалтай/;* ❖ *ОУ-ын стандарт шаардлагад нийцсэн усан сантай байх /150 хүүхдийн үзэгчийн суудалтай/.* **А БЛОК** **Спорт заал:** - 500 хүүхдийн үзэгчийн суудалтай; - Чийрэгжүүлэх танхим; - Хувцас солих өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Дүш /эрэгтэй эмэгтэй/; - Багш дасгалжуулагчийн өрөө; - Спрот хэрэгслийн агуулах; - Спортын бусад төрлийн бэлтгэлийн танхим /2/. **Усан сан:** - 25 метрийн урттай 4 зам бүхий усан сан; - Багш, аврагчийн өрөө; - Хувцас солих өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Дүш /эрэгтэй эмэгтэй/; - Зоорийн давхарт техникийн өрөө; - Ажилчдын өрөө; - Спорт хэрэгслийн агуулах. **Б БЛОК** **Зоорийн давхарт:** - Техникийн өрөө; - Агуулах; - Ажилчдын өрөө; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/. **Бусад давхарт:** - Зохион байгуулагчын өрөө; - Арга зүйчийн өрөө /бүтээлийн архивын өрөө/; - Багш нарын өрөө; - Үйлчилгээний ажилтны өрөө; - Эмчийн өрөө; - Анхан шатны тусламжийн өрөө; - Хяналтын өрөө /камер/; - Музей; - Одон орны танхим; - Дүрслэх урлагийн танхим; - Монгол ёс заншлын танхим; - Алдартнуудын танхим; - Гамшгаас хамгаалах сургалтын өрөө; - Байгалийн танхим; - Шинжлэх ухааны танхим; - Түүх, газар зүйн танхим; - Технологи инновацын танхим;

		- Гадаад хэлний танхим; - Бүжгийн танхим; - Хөгжмийн танхим; - Студи /танхим/; - Лаборатори, танин мэдэхүйн өрөө; - Бусад жижиг сургалтын танхимууд; - Номын сан; - Давхар бүр нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/; - Кофе шоп; - Хүнсний дэлгүүр, буфет. ❖ *Аваар ослын үед хүүхдүүд богино хугацаанд танхимаас гарах 4-өөс доошгүй хаалга төлөвлөх;* ❖ *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангасан байх.* **4. ЗАХИРГААНЫ БАРИЛГА** - Захирлын өрөө /нарийн бичгийн өрөөтэй байна/; - Аж ахуйн алба /2/; - Хөтөлбөрийн алба /2/; - Захиргааны алба /3/; - Санхүүгийн өрөө /3/; - Агуулах /2/; - Хурлын заал /1/; - Зочин хүндэтгэлийн өрөө /1/; - Уулзалтын өрөө /1/; - Цайны өрөө /1/; - Архивийн өрөө /2/; - Дотоод сүлжээний өрөө /1/; - Камерын хяналтын өрөө /1/; - Техникийн өрөө /2/; - Техникийн ажилтны өрөө; - Ариун цэврийн өрөө /эрэгтэй,эмэгтэй/; - Ажилчдын хоолны газар /100 хүн/; - Автомашины зогсоол /30 машин/. **5. ЭМНЭЛЭГИЙН БАРИЛГА** - Үүдний буюу угтах хэсэг; - Өлгүүр; - Хүлээлгийн өрөө; - Их эмчийн өрөө; - Эмч нарын өрөө; - Сэтгэл зүйчийн өрөө; - Сувилагч тарианы өрөө; - Мэс ажилбарын өрөө; - Боолтны өрөө; - Ариутгал, халдваргүйжүүлэлтийн өрөө; - Шүдний эмчийн өрөө;

		- Тусгаарлах өрөө 2 /өрөө бүр дотроо ариун цэврийн өрөө, шүршүүртэй, гадагшаа шууд гарах хаалгатай байх/; - 2 ортой хэвтэн эмчлүүлэх өрөө 4 /өрөө бүр дотроо ариун цэврийн өрөө, шүршүүртэй/; - Эм тариа хадгалах өрөө; - Үзлэгийн өрөө; - Эмчилгээний өрөө; - Ариун цэврийн өрөө /эр,эм/; - Хувцас солих өрөө; - Үйлчлэгчийн өрөө; - Хяналт, камерийн өрөө. **6. А.ӨВЛИЙН ХООЛНЫ ГАЗРЫН БАРИЛГА** - Хувцасны өлгүүр; - Нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй,эмэгтэй/; - Тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө; - 1 ээлжиндээ 500 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай хооллох заал. ***Өвлийн хоолны газрын халуун цех:*** - Түүхий эд хүлээн авах талбай; - Хөргөлттэй, хөргөлтгүй агуулах; - Хуурай хүнсний агуулах; - Өндөг, нарийн ногооны агуулах; - Ногоо боловсруулах цех; - Халуун хоол хүнс боловсруулах цех; - Талх нарийн боовны цех; - Талх зүсэх өрөө; - Хоол таваглах хэсэг; - Үйлчилгээний сав угаалга; - Ажилчдын хувцас солих өрөө; - Ажилчдын 00, дүш; - Ажилчдын түр амрах өрөө; - Ерөнхий технологичийн өрөө; - Ахлах тогоочын өрөө; - Хүнсний няравын өрөө; - Эрүүл ахуйчын өрөө; - Хог хаягдал ангилан ялгах цех; - Хүнсний лифт; - Цехүүдийн хооронд канверийн системтэй. ❖ *Аваар ослын үед хүүхдүүд богино хугацаанд танхимаас гарах стандартад заасан тоогоор хаалга төлөвлөх;* ❖ *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангасан байх.* **6. Б.ЗУНЫ ХООЛНЫ ГАЗАР** **Хүчин чадал: 500 хүүхдийн хүчин чадалтай:** - Хувцасны өлгүүр;

		- Хүрэлцэхүйц тооны гар угаалтуур төлөвлөх; - Нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй,эмэгтэй/; - 1 ээлжиндээ 500 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай хооллох заалтай байхаар төлөвлөх; - Хүнс, бэлэг дурсгалын дэлгүүртэй. ***Зуны хоолны газрын халуун цех:*** - Түүхий эд хүлээн авах талбай; - Хөргөлттэй, хөргөлтгүй агуулах; - Хуурай хүнсний агуулах; - Өндөг, нарийн ногооны агуулах; - Ногоо боловсруулах цех; - Халуун хоол хүнс боловсруулах цех; - Хоол таваглах хэсэг; - Үйлчилгээний сав угаалга; - Ажилчдын хувцас солих өрөө; - Ажилчдын 00, дүш; - Ажилчдын түр амрах өрөө; - Ахлах тогоочын өрөө; - Хог хаягдал ангилан ялгах цех. ❖ *Аваар ослын үед хүүхдүүд богино хугацаанд танхимаас гарах 2-оос доошгүй хаалга төлөвлөх.* **7. ЗОЧИД БУУДАЛ** **Зоорийн давхар** - Техникийн өрөө; - Дулаан зогсоол. **1 давхарт** - Ресторан /50 хүний хүчин чадалтай/; - Кофе шоп; - Гал тогоо; - Агуулах өрөө; - Ажилчдын өрөө; - Хурлын өрөө; - Хүлээн авах хэсэг; - Саун; - Нийтийн ариун цэврийн өрөө /эрэгтэй,эмэгтэй/; - Үйлчилгээний өрөө; - Ажилчдын ариун цэврийн өрөө. **2-3 давхарт** - 1 ортой 5 өрөө; - 2 ортой 10 өрөө; - Гэр бүлийн 3 өрөө; - Өрөө бүр ариун цэврийн өрөө, шүршүүртэй. ❖ *Тухайн өрөөнүүдийг норм, норматив стандартын шаардлагыг хангахаар төлөвлөх;* ❖ *Аваар ослын үед хүүхдүүд богино хугацаанд танхимаас гарах 2-оос доошгүй хаалга төлөвлөх;* ❖ *Тусгай хэрэгцээт иргэнд зориулсан өрөөг төлөвлөх.*

		8. ГАДНАХ БАЙГУУЛАМЖ, ТОХИЖИЛТ *Хөтөлбөр, үйл ажиллагаанд*: - Ёслолын талбай /1000 хүүхдийн багтаамжтай/; - Усан парк; - Усан онгоцны зогсоол /Хөтөлбөр болон үйлчилгээнд ашиглах/; - Ферм /хөтөлбөрт хэрэглэх/; - Аяллын отог; - Ногоон байгууламж /цэцэрлэгт хүрээлэн/; - Зуслангийн хэсэг тойроод унадаг дугуйн замтай байх; - Спортын талбай. ✓ Сагсан бөмбөгийн талбай /4/ ✓ Гар бөмбөг /2/ ✓ Элсний гар бөмбөг /2/ ✓ Хөлбөмбөгийн талбай том /1/ ✓ Хөлбөмбөгийн талбай жижиг /1/ ✓ Сурын талбай /1/ ✓ Буудлагын талбай /1/ ✓ Экстрим спортын байгууламж /2/ **9. АЖИЛЧДЫН ОРОН СУУЦ** Хүчин чадал: 72 айлын орон сууц: - 3 давхар; - 1-2 өрөөгөөр төлөвлөх; - Зоорийн давхартаа дулаан зогсоол, техникийн өрөөтэй. **10. АВТОГРАЖ** - 30 машины граж /том оврын автобус, автомашин орох боломжтойгоор төлөвлөх/; ✓ Деспетчерийн өрөө ✓ Ажилчдын хувцас солих өрөө ✓ Ариун цэврийн өрөө ✓ Дүш - Аж ахуйн агуулах /3/; - Засварын цех; - Дархан, мужааны цех.
9.	Инженер шугам, сүлжээнд тавигдах шаардлага	**<u>Дулаан хангамж</u>** - Бие даасан **<u>Ус хангамж /хэрэгцээний халуун, хүйтэн ус хангамж/</u>** - Бие даасан **<u>Ариутгах татуурга</u>** - Бие даасан байдлаар/; - Бага оврын цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж, шугам хоолой.

		<u>Цахилгаан хангамж</u> - Техникийн нөхцөлөөр болон нөөц эх үүсвэр <u>Холбоо дохиолол</u> - Техникийн нөхцөлөөр; Шилэн кабел. /Интернет, кабелын телевиз, телефон, галын болон хамгаалалтын бусад системүүд/. <u>Автоматжуулалт</u> - Техникийн нөхцөлөөр. <u>**Усны барилга, байгууламж**</u> - Инженерийн бэлтгэл арга хэмжээ авах; - Ус зайлуулах, цуглуулах далан суваг. <u>Хатуу хог хаягдал</u> - Хог хаягдлыг ангилан цуглуулах талбай, ялган хадгалах хэсэг. <u>**Бохир хог хягдал**</u> - Бохир хог хаягдлыг ангилан цуглуулж, устгах талбай. <u>**Сул тогийн системүүд**</u> Телефон ба видеотелефон холбоо; шуурхай холбоо; тооцоолон бодох компьютерийн дотоод сүлжээ, радиожуулалт, цахилгаан цагны систем.
10.	Инженер-геологийн судалгааны талаарх шаардлага	Тухайн ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.
11.	Газар хөдлөлийн баллны шаардлага	Магадлалаар баталгаажсан инженер геологийн судлагааны дүгнэлтээр тодорхойлогдоно.
12.	Зураг төсөл боловсруулах ажлын үе шат	Бэлтгэл ажил: - Газрын захирамж, гэрчилгээ; - Архитектур төлөвлөлтийн даалгавар; - Техникийн нөхцлүүд; - Байгаль орчны үнэлгээ; - Инженер геологийн судалгаа /зургийн байгууллага гүйцэтгүүлнэ/; - Урьдчилсан ТЭЗҮ - Батлагдсан загвар зурагт үндэслэн боловсруулах. Зураг төслийн үе шат: - Загвар зураг /Батлагдсан загвар зураг-гадна экстерьер, дотор интерьерийн зургууд багтсан байна/; - Барилгын иж бүрэн ажлын зураг, төсөв /барилгын ажлын зурагт тайзны технологийн зураг, гадна экстерьер, тохижилт, дотор интерьерийн зургууд нэмж багтана/; - Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөв.

13.	Ашиглах материал	**Монгол Улсын хууль, тогтоомж:** Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад хэрэглэх хүчин төгөлдөр хууль, тогтоомжууд. **Норм, нормативууд:** Монгол Улсын Барилгын норм, дүрмийн хүрээнд: Барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрэм болон дор дурдсан барилгын дүрмүүдийг мөрдлөг болгоно. - Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах аргачилсан заавар /БД 30-103-21/ - Захиргааны зориулалттай олон нийтийн барилга; - Орон сууц, олон нийтийн барилгын байгалийн гэрэлтүүлэг /БД 31-110-11/; - Барилга байгууламж, өрөө тасалгааны тэсрэх, шатах галын аюулын ангиллыг тодорхойлох дүрэм /БД 21-101-12/; - Дээврийн хучлага ба төлөвлөлт /БД 31-117-15/; - Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм ба дүрэм БНбД 22-01-01*/2006/2013 БНбД 22-01-01*/2006/2013/; - Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12/*2020/; - Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага /БД 31-101-04/; - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа /БД 11-102-07/; - "Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах" барилгын дүрэм /БД 43-102-07/; - Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар /БД 43-103-0/; - Эталон зураг; - Мөн олон улсад хэрэглэж буй хүлээн зөвшөөрөгдсөн норм, дүрэм, стандарт. **Дүрэм, журам, стандартууд:** - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/; - Явган хүн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056:2009/; - Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцон орон зай, орчин /MNS 6055:2009/; - Цахилгаан тоног төхөөрөмж, гүйдэл дамжуулагчийн таних тэмдэглэгээ. Ерөнхий шаардлага /MNS 3757-16:2015/; - "Бүдүүвч дэх автоматжуулалтын хэрэгсэл ба багажийн таних тэмдэглэгээ" /MNS 4187-93/; - "Олон улсын цахилгаан техникийн хорооны таних тэмдэглэгээ" /MNS IEC 60617/; - Барилгын зураг төслийн баримт бичгийн систем, холбоо ба дохиоллын ажлын зураг" -MNS 6586:2016 стандарт; - Холбоо, мэдээлэл, дохиоллын кабель шугам ба тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ" MNS 5532:2016 стандарт;

		- Барилгын дотор холбоо дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт хийх" /MNS 5471:2005 стандарт/; - Барилгын эталон зураг хэрэглэх заавар; - Хүүхдийн зуслангийн стандарт, ерөнхий шаардлага /MNS 5633:2019 стандарт/; - MNS 6055: 2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага"; Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 6476 : 2014. **Бусад холбогдох норм, дүрэм:** - Дээрх хууль болон норм, нормативын баримт бичгүүдэд зааснаас бусад болон онцгой шаардлагатай тохиолдолд олон улсын норм, дүрмийг баримтална.
14.	Ажлын зургийн бүрдэл	**1. Загвар зураг** - Нүүр хуудас; /батлагдах/ - ЕТ- Ерөнхий төлөвлөгөө М1:500; - Төлөвлөлтийн санаа шийдэл; - Авто замын хөдөлгөөний схем М1:500-1000; - Нийтийн тээврийн хөдөлгөөний схем М1:500-1000; - Явган хүний хөдөлгөөний схем М1:500-1000; - Нарны ээвэрлэлт; - Орчны тойм; - Тохижилт ногоон байгууламж М1:500; - Харагдах байдал; - Байгуулалт М1:100; - Барилгын огтлол М1:100; - Нүүр тал, хажуу тал М1:100; - Гудамжны дэлгээс М1:500-1000; - Интерьерийн шийдэл. **2. Иж бүрэн ажлын зураг** - Ерөнхий төлөвлөгөө; - Барилга архитектур; - Технологи; - Барилга бүтээц; - Тайзны технологи; - Сантайз; - Халаалт агаар сэлгэлт; - Цэвэр бохир ус; - Хүчит төхөөрөмж дотор гэрэлтүүлэг; - Холбоо дохиолол; - Автоматик; - Гал унтраах систем; - Гадна дулаан хангамж; - Гадна ус хангамж, ариутгах татуурга; - Гадна цахилгаан хангамж; - Гадна холбоо; - Гадна гэрэлтүүлэг;

		- Интерьер; - Макет М1:500; Анимейшн /5 минутаас багагүй байх/. **3. Төсөв** - Магадлал хийсэн ажлын зураг төслийн дагуу төсвийг *эрх бүхийн байгууллагаас зөвшөөрсөн программаар* гүйцэтгэх. *Зураг төслийг боловсруулах, тооцоо, судалгаа хийх үед зураг төслийн иж бүрдэл нэмэгдэх боломжтой.* **Ажил гүйцэтгэх аргачлал:** - Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн дагуу боловсруулж, магадлал хийлгэсэн эх загвар зураг болон иж бүрэн ажлын зураг, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт Монгол хэл дээр эх хувь 1 хувь, хуулбар 3 хувь хэвлэмлээр, файл хэлбэрээр CD-д бичиж 1 хувь хүлээлгэн өгнө.
15.	Галын аюулгүй байдлын нөхцөл	• Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал /БНбД 21-01-02/; • Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/.
16.	Техник эдийн засгийн үндэслэл	• Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг батлагдсан загвар зурагт тулгуурлан боловсруулна. Захиалагч байгууллагаар батлуулах; • ТЭЗҮ-ийг Монгол хэл дээр боловсруулах.
17.	Ажлын үе шатанд тавигдах шаардлага	• **Суурь** Инженер геологийн судалгаагаар гарсан дүгнэлтийг үндэслэж төлөвлөх. • **Барилгын үндсэн хийц** Барилга бүтээцийн тооцоо судалгааны төлөвлөлт. /Цутгамал төмөр бетон хийцтэй байх. • **Хучилт** Цутгамал төмөр бетон хучилттай байна. Хол алгасалтай заалны хучилтыг метал хийцээр шийдэх. • **Гадна хана** Тус барилгын гадна хаших ханыг дулаан техникийн тооцоо, холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн дуу, дулаан, уур ус тусгаарлалтын өндөр түвшинд төлөвлөх. • **Гадна ханын өнгөлгөө** Орчин үеийн шийдэл шинэ технологийг тусгасан материал байх; Барилгын гадна өнгө болон дизайн хүүхдийн сэтгэл зүй, гоо сайхны мэдрэмжинд сайнаар нөлөөлөх уран сайхны шийдэлтэй байх тул гадна экстрьерийн зурагтай байх; Барилгын фасаданд гэрэлтүүлэг төлөвлөх. • **Дотор хамар хана, тааз** - Өрөө тусгаарлах хана нь гипсэн /КНАУФ/, евро блок, тоосго;

		- Тааз гипсэн болон дүүжин тааз /дүүжин тааз нь галын шаардлага хангасан материал байх/; - Шаардлагатай хэсгүүдэд засвар үйлчилгээ үзүүлэх нээлхий төлөвлөх; - Дотор интерьерийн өнгө дизайн нь хэт хурц, хүйтэн өнгөний хоршилгүй байхаас гадна хүүхдийн сэтгэл зүй, гоо сайхны мэдрэмжид сайнаар нөлөөлөх шийдэлтэй байх; - Дотор гадна заслын ажлын материалд эрүүл ахуйн шаардлага хангасан, эдэлгээ удаан чанартай материал төлөвлөх. • **Шалны өнгөлгөө** - Үүдний хэсэг болон шат, шатны хонгилд цайвар өнгийн чулуун хавтан төлөвлөх; - Плитан шал сайн чанарын халтирдаггүй плита төлөвлөх; - Хулдаас шал 4.5 мм –ээс дээш зузаантай зөөлөн артай халтирдаггүй, зурагддаггүй эрүүл ахуйн шаардлага хангасан шал төлөвлөх, галд тэсвэртэй байх. • **Дээвэр** Хавтгай дээвэр төлөвлөнө. • **Дулаалга** Чулуун эрдэс хөвөн хавтан. • **Шилэн хана, цонх** Металл рамтай шилэн хана, металл рамтай 3 давхар шилтэй вакум цонх төлөвлөнө. • **Цахилгаан шат** - Барилгад шаардлагатай цахилгаан шатыг хүлээлтийн хугацаанаас хамаарч төлөвлөх ба норм, дүрмийн шаардлагыг хангасан байна; - 750 кг даацтай зорчигчид болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 1 лифт; - 2000 кг даацтай ачааны зориулалттай 1 лифт. • **Халаалт, Агаар сэлгэлт, Агаарын кондиционер ба Хүйтэн хангамж** - Халаалт, халуун ус, агаар сэлгэлт, агаарын кондиционерийн дулаан хангамжийг төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрээс хангахаар төлөвлөх; - Агаарын температурын зөвшөөрөгдөх хэмжээ нь Захиргаа 22°C-25°C, өвлийн амралтын төв байр, сургалт, хөгжил бүтээлийн ордны хэсэгт 22°C-25°C, урлаг соёлын ордон 18°C-23°C, чийглэг -76 % байх; - Өвлийн амралтын байр, сургалт хөгжил бүтээлийн ордон, урлаг соёлын ордны барилгын гадна хашлага бүтээцээр алдах дулаан, агаарын горимын тооцоо, агаар хүлээн авах байгууламжийн байрлаж буй газрын гадна агаарын тооцооны үзүүлэлт зэргийг /БНбД 23-01-09/ дагуу агаарын температур, хурд зэргийг тооцох; - Барилгын агаар өгөх ба зайлуулах системийг ердийн болон албадмалаар төлөвлөх;

		- Агаар сэлгэлтийн системд дуу чимээ үүсэхээс сэргийлж сараалжаар өнгөрөх бохир агаарын хурдыг тооцох; - Агаар сэлгэлтийн систем нь нормын дагуу цэвэр агаар сэлгэдэг, 3 давхар шүүлтүүртэй, шүүлтүүрээс гарах агаарыг чийгшүүлдэг байх; - Хөргөлтийн систем нь Duct Fan Coil System байх; - Утаа зайлуулах хамгаалах агаар өгөх системийн агаар сорох хэсэгт утаа орохгүй байх; - Хүйтэн хангамжийн системийг үйлчилж буй өрөө, тасалгааны үйл ажиллагааны зориулалт, системийн элементүүдийн даралт даах хязгаар зэргээс хамааруулан өндрийн дагуу бие даасан бүс болгонд тус тусад нь төлөвлөх; - Барилгын хүйтэн хангамжийн системд хоёроос багагүй хөргөлтийн машин эсвэл бие даасан хоёроос багагүй хөргөлтийн эргэлттэй нэг машиныг сонгох. Машин бүрийн хүчин чадал нь хүйтэн хангамжийн 50-иас доошгүй хувийг хангахаар тооцох. • **Усан хангамж, ариутгах татуурга, борооны усны систем** - Унд ахуйн /халуун, хүйтэн/, бохир болон гал унтраах усны шугамыг нормын дагуу төлөвлөх; - Салбар шугамаас бусад хүйтэн, халуун усны шугамын бүх хоолойг /хүйтэн усны шугамыг хөлрөхөөс, халуун усны шугамыг дулаан алдахаас хамгаалж/ шатдаггүй бүлэгт хамрагдах материалаар тусгаарласан байх; - Насоснууд болон бусад төхөөрөмжүүдийг гар болон алсын удирдлагатай байх мөн тэдгээрийн автомат горим дээрх ажиллагааг удирдах системийг төлөвлөх; - Зоорийн давхарт өөрийн урсгалаар бохир ус зайлуулах боломжгүй түвшин дэх ус зайлуулах сувгийг (дренаж) автомат горимоор ажиллах насосны төхөөрөмж болон бохир усны системд зориулсан тусгай зориулалтын бохир усны хаалт эсвэл төрөл бүрийн үл буцах хаалттай байхаар төлөвлөх; - Борооны ус зайлуулах дотор шугам нь дээврийн бороо, цасны ус, хонгил болон техникийн өрөөнөөс гал унтраасан усыг зайлуулах бололцоотой байх; - Дээвэр дээрх ус зайлуулах юүлүүрүүдийг цас хайлах үеийг тооцож суурилуулах. Юүлүүрүүдийг босоо шугам руу зөөлөн богино холбоосоор холбох; - Спинклер системийг норм дүрмийн дагуу төлөвлөх; - Усан шүршигч (спинклер) ашиглах төхөөрөмжтэй бүх өрөө, давхруудад трапнууд болон дүүжин насос бүхий нүхийг төлөвлөх; - Усаар унтрах боломжгүй зургийн даалгавраар тодорхойлсон өрөө тасалгаанд хийгээр гал унтраах автомат систем төлөвлөх; - Борооны ус зайлуулах шугамыг төлөвлөхдөө ногоон байгууламжийн усалгааны системтэй уялдуулж төлөвлөх. • **Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг:**

		- Амрах, сурах, байрлах зориулалттай өрөөний төлөвлөлтөд байгалийн гэрэл өдрийн турш, урт хугацаанд тусахаар төлөвлөж өгөх; - Барилгын гадна фасадны гэрэлтүүлэг төлөвлөх; - Өрөөнүүдэд абажур, нүдэн гэрэл, туузан гэрэл угсрах тэжээл төлөвлөх; - Давхрын коридор болон шатны эргэх талбайд мэдрэгчтэй гэрэл төлөвлөх; - Давхрын коридорт ослын гэрэл буюу тог баригчтай гэрэл "ГАРАХ" бичигтэй гарцын таних тэмдэг бүхий гэрэл төлөвлөх; - Давхрын коридорт цэвэрлэгээний зориулалттай залгуур төлөвлөх; - Халаалт хөргөлтийн системүүдийн тэжээлийг төлөвлөх /байрлалыг халаалт агаар сэлгэлтийн зурган дээрээс харах/; - Камеруудын байрлалуудад цахилгаан тэжээл төлөвлөх; - Шалган нэвтрүүлэх хяналт тавих системийн байрлалд цахилгааны тэжээл төлөвлөх; - Давхар бүрт камерын цахилгааны тэжээл төлөвлөх; - Цахилгаан тоолуур нь өдөр шөнийн тарифтай импульсийн тоолууraар төлөвлөнө. <u>Цахилгааны утас, түүнд тавигдах шаардлага:</u> МУ-ын барилгын цахилгаан угсралтын норм дүрэмд тохирсон тухайн горимд тохирох шаардлага хангасан утас, кабелийг сонгоно. - Үндсэн босоо магистраль шугамуудыг хатуу, шулуун ПВХ хоолойд сүвлэнэ; - Далд угсрах цахилгааны хамгаалалтын хоолойг уян хоолойгоор ил угсрагдах цахилгааны утасны хамгаалалтын хоолойг хатуу шулуун ПВХ хоолойгоор тооцно; - Салбар шугамуудыг уян хоолойд сүвлэн шал таазаар угсралт хийх. Ямар нэг сантехникийн усны сувагтай давхцаж байгаа эсэхийг сайтар нягтлах, давхцуулахгүй байх; - Зоорийн давхрын сантехникийн хоолойнуудаас цахилгааны кабелийн трасс аль болох хол зөрөхөөр тооцоолж зурганд төлөвлөх; - Барилгын гадна гэрэлтүүлгийн сувагчлалыг ган хоолойд эсвэл хуванцар хоолойд сүвлэж тоосгон хамгаалалт төлөвлөх; - Босоо магистралийн шугамуудыг аль болох дутаахгүйгээр нөөцтэй авах хоолойны диаметр, нийт тоог зөв тодорхойлох; - Цахилгаан зарцуулалт багатай, гэрэлтүүлгийн хэмжээнд хүрсэн засвар үйлчилгээ хийхэд хялбар тоног төхөөрөмжийн сонгоно; - Унтраалга, залгуур зэрэг тоноглолууд болон тэдгээрт тавигдах шаардлага. <u>Онцгойлон тусгуулах бусад даалгавар:</u> - Барилгын дотор болон гадна төлөвлөлтүүд хүүхдийн нас бие онцлогт тохирсон хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлсэн байх;

		- Барилгын дотор болон гадна заслын ажил болон тохижилтын ажилд хэрэглэх материал хүүхдэд харшил өгөхгүй, хоргүй, аюулгүй нөхцөлийг хангасан байх; - Сантехникийн тоног төхөөрөмжүүд; - IT-гийн тоног төхөөрөмжүүд; - Галын тоног төхөөрөмжүүд г.мэт; - Гадна гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчээр /нарны зайн системээр/ хангахаар сонгож зурганд тусгаж өгөх; - Урлаг соёлын ордны бүх жүжигчдийн өрөө болон бэлтгэлийн өрөөг тайз болон удирдлагын өрөөнд дуудах холбооны шугам, дэлгэцтэйгээр төлөвлөх; - Барилгад зарлан мэдээлэх систем төлөвлөх. • **Холбоо, дохиолол:** - Давхар бүрт холбооны самбар төлөвлөх; - Галын бүс бүр бие даасан аналог-хаягийн галын дохиололтой байх бөгөөд хоорондоо гогцоо маягаар холбогдсон байна; - Галын дохиоллын мэдээлэгчүүдийг ариун цэврийн өрөөнөөс бусад бүх өрөөнд төлөвлөнө; - Дохиолол нь удирдлагатай байхаас 24 цагийн харуул хамгаалалттай өрөөнд байрлах бөгөөд түүнд барилгын галын нэгдсэн самбар, дохиоллыг төлөвлөнө. <u>Smart Home Automation систем нь:</u> - Бүх цонх, хаалганд хулгайн болон хөдөлгөөн мэдрэгчүүдтэй холбогдсон ажиллах. <u>Утас, кабель болон сувагчлал:</u> - Энэ системийг гурвалсан IP үйлчилгээний сүлжээ хийх замаар шийдвэрлэнэ; - Хамгийн сайн чанарын, кабель сонгох CAT6. <u>Интернэт холболт:</u> - Олон интернэт үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйлчилгээг нэг дор, олон сонголтоор хүлээн авах нөхцөлийг хангах; - Зоорийн давхрын серверийн өрөөнд телефон холбооны кросс төлөвлөх; - Бүх өрөөнүүдэд спикер төлөвлөж аудио системтэй холбон хөгжмийг бүх өрөөнөөс сонсохоор төлөвлөнө; - Ариун цэврийн өрөөнөөс бусад бүх өрөөнд интернэтийн үзүүр оруулна. <u>Хяналтын систем:</u> - Авто зогсоолд шалган нэвтрүүлэх, хяналт тавих систем байна; - Дүрст ажиглалтын системийн камерууд бүх орц, гарцууд, гадна фасад, орчны явган хүний зам, автозамыг харах боломжтойгоор төлөвлөнө; Камерууд нь хүний царай, авто машины номер таньж чадах нарийвчлалтай байна. Бичлэгийг хоёр сарын хугацаанд хадгалах боломжтой байна; - Хулгайн дохиоллыг бүх өрөө, орц гарц, цонхонд төлөвлөх;

		- Лифт, лобби, давхар болгоны коридорт хяналтын камер төлөвлөнө. Галын дохиолол, гал илрүүлэх, унтраах системийн автомат удирдлага нь дараах системүүдийг удирдана: - Гал түймрийн үед утаа зайлуулж, хонгилуудад даралттай агаар өгөх систем төлөвлөх; - Галын усны нөөц бэлдэж, түймрийн үед галын крануудыг даралттай усаар хангах систем төлөвлөх; - Дуут дохио төлөвлөх; - Лифтний урд талын коридорт утаа болон дулаан мэдээлэгч, шатны хонгил, техникийн өрөө, лифтний хонгилд утаа мэдээлэгч төлөвлөх; - Зарлан мэдээлэх систем төлөвлөх. Барилгуудын Инженерийн төхөөрөмжүүдийн автомат удирдлагын системийн талаар: - Агаар сэлгэлтийн систем, Хөргөлтийн систем, Цэвэр усны даралт өргөх систем, Бохир ус зайлуулах дернажийн систем, халаалт, хэрэгцээний халуун ус хангамжийн төв зангилаа, Галын усны автомат систем, утаа зайлуулах систем.
18.	Онцгой нөхцөл	Ерөнхий нөхцөл: - Барилга байгууламж, гадна орчны тохижилтыг төлөвлөхдөө "Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль", "Хүүхэд хамгааллын бодлого" зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан стандарт шаардлагуудыг харгалзан үзэх; - Хүүхдийн зуслангийн стандарт, ерөнхий шаардлага /MNS 5633:2019 стандарт/ -ыг хангах; - Барилгын дотор болон гадна заслын ажилд ашиглах материал нь эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай материалуудыг тусган өгөх /Захиалагч, ашиглагчын саналыг тусгаж өгөх/; - Байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжыг тусгах ба эрчим хүчний хэмнэлттэй байх; - Орчин үеийн дэвшилтэт технологийг төлөвлөлтөд тусгах; - Гамшигийн менежмент, онцгой байдлын газар, гал унтраах анги, хамрах хүрээ аюулын дуут дохио, хоргодох байр, түр цуглах талбайн хүчин чадал хүрэлцээг тодорхойлох; - Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх; - Байгалийн гамшигийн /үер, газар хөдлөлт, гал түймэр г.м/ эрсдлийг сайтар тооцоолж зураг төсөл хийх, барилга байшингийн хийц материалыг сонгох.
19.	Боловсруулах хугацаа	Гэрээнд заасан хугацаагаар
20.	Хөрөнгө оруулалт.	2021, 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжинэ.
21.	Захиалагч байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

22.	Зураг төсөл боловсруулах байгууллага	Барилгын тухай хуулийн 19.1.1-д засан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага.
23.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг "Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12*2020/"-ийн дагуу тооцож, эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар гүйцэтгэсэн байна. **Нэгдсэн төсөвт өртөг:** - Зураг төслийн үнэ; - Захиалагчийн хяналтын зардал; - Зохиогчийн хяналтын зардлыг норм, дүрмийн дагуу тус тус тооцож тусгасан байна.
24.	Зөвшилцөх байгууллага	Ажлын зургийн шатанд холбогдох байгууллагаас санал авч, төлөвлөлтийн шатанд зөвшилцөж авто замын сүлжээ, бүсчлэл, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг гаргах; /"ДШС" ХК, "УБЦТС" ХК, УСУГ, МЦХ, НАЗХГ, НАЖГ, НСУГ, НХБХГ, НМХГ, НОБГ/

ХЯНАСАН:

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч — Д.ГАНТУЛГА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга — Н.БАЯРМАА

БОЛОВСРУУЛСАН:

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч — Т.БАТЦЭНД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн ам, хөгжлийн газрын мэргэжилтэн — Э.БАДАМХАНД

Олон улсын хүүхдийн найрамдал-2 зуслангийн Ашиглалтын өмнөх захиргааны дарга — О.ДОРЖСҮРЭН

ТУ3894
9132155
1119277787